



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ  
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠨ  
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ  
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2022 оны 06 сарын 28 өдөр

Дугаар А/396

Алтай хот

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.5 дахь заалт, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2022 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн 14 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сангийн яамны Төсвийн хөрөнгө оруулалтын газрын мэргэжилтнүүд, Дэлхийн банкны “Төсөв, санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх” төсөл, Азийн хөгжлийн банкны “Төсвийн санхүүгийн удирдлагын ил тод үр ашигтай байдал” төслийн зөвлөхүүдтэй хамтран Ховд, Дархан-Уул аймагт баруун болон төвийн аймгуудын төлөвлөлт, хэрэгжилт, санхүүжилтийн үйл ажиллагааг хариуцдаг албан хаагчдад улсын төсвийн хөрөнгө оруулалтын аргачлал, төслүүдийг үнэлэх, эрэмбэлэх, сонгох, цахим системээр төлөвлөх, санхүүжүүлэх бүсийн уулзалт, сургалт зохион байгуулсантай холбогдуулан Сангийн яам болон аймгуудын төлөөлөлд нутгийн брэнд бүтээгдэхүүнийг сурталчилан танилцуулахад шаардагдах 7 багц 175,000 (нэг зуун далан таван мянга) төгрөгийн үнэ бүхий нутгийн брэнд бүтээгдэхүүнийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газар (Ц.Батзориг)-д зөвшөөрсүгэй.

2. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Г.Чинбат)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР